

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан	8
3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3.6. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН
ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН
ХӨГЖЛИЙН G0204-MON ТӨСӨЛ”-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б. ОЮУН ТАНАА

2020.04.13 № 06/1125
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл” 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл” нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Б.Оюун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-аас 2020 оны 3 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Болорцэцэг, туслах аудитор Ц.Баттуяа нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн бол “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь төсөлд хамрагдсан хотуудын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэн ажиллахад оршино.

Төслийн хүрээнд 6 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд шаардагдах дэд бүтцийн барилга байгууламжийг барих, түүний ашиглалт үйлчилгээг зохицуулах оператор компанийг байгуулж, чадавхжуулах зэрэг ажлуудыг хамарсан цогц шийдэл гарган ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 295,021.7 мянган төгрөгөөс тооцон 2,950.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,330.8 мянган төгрөгөөр буюу 51 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	144,341.2	91,087.0	(53,254.2)
Үндсэн хөрөнгө	42,076.6	-	(42,076.6)
Нийт хөрөнгө	186,417.8	91,087.0	(95,330.8)
Өр төлбөр	-	45,105.0	45,105.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	186,417.8	45,982.0	(140,435.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	186,417.8	91,087.0	(95,330.8)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл” нь 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хаагдаж байгаатай холбогдуулан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 53,254.2 мянган төгрөгөөр буурч, 42,076.6 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг “Зүүн өмнөд говийн хот, байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн L3388-MON төсөл”-д шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь 6,150.4 мянган төгрөгийн аудитын үйлчилгээний төлбөр, 38,954.6 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлэх хүүгийн орлогоос тус тус шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 101,481.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийг хэрэгжүүлэхэд зориулан 235,200.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 235,200.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг гадны хандив, тусламжийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Төслийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 144,341.2 мянган төгрөг байсан бол гүйцэтгэлээр 139,625.8 мянган төгрөгийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас авч, харилцах дансны хүүгийн орлого 39,602.8 мянга, бусад орлого 5,700.7 мянга, нийт 184,929.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 235,088.6 мянган төгрөгийг зарцуулж, 3,094.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, 91,087.0 мянган төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 235,088.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай холбоотой 38,954.6 мянган төгрөгийн дараах асуудлыг залруулан санхүүгийн тайлант тусгаж, “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд хамаарах 37,507.9 мянган төгрөгийн улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг, 1,446.7 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.” заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-MON төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,341,214.36	91,087,036.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	144,341,214.36	91,087,036.82
312	Банканд байгаа бэлэн мөнгө	144,341,214.36	91,087,036.82
3121	Төгрөг	402,161.74	-
31211	Төрийн сангийн харилцах	402,161.74	-
3122	Гадаад валют	143,939,052.62	91,087,036.82
31223	Арилжааны банк дахь харилцах	143,939,052.62	91,087,036.82
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,076,626.51	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,076,626.51	-
392	Биет хөрөнгө	42,076,626.51	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	90,120,364.69	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(90,120,364.69)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,096,315.89	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,521,886.89)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,526,635.00	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,024,437.49)	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	1,320,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,320,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	186,417,840.87	91,087,036.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	45,105,048.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	45,105,048.13
413	Өглөг	-	45,105,048.13
4136	Бусад өглөг	-	45,105,048.13
41361	Байгууллагад төлөх өглөг	-	45,105,048.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	186,417,840.87	45,981,988.69
51	Засгийн газрын хувь оролцоо	186,417,840.87	45,981,988.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,205,075.03	15,205,075.03
512	Хуримтлагдсан үр дүн	171,212,765.84	30,776,913.66
51210	Өмнөх үеийн үр дүн	594,136,328.93	171,212,765.84
51220	Тайлант үеийн үр дүн	(422,923,563.09)	(140,435,852.18)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	186,417,840.87	91,087,036.82

3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,540,952.82	187,839,724.28
110	Орлогын албан татвар	-	(3,750,789.50)
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,540,952.82	187,839,724.28
120	Нийтлэг татварын бус орлого	3,540,952.82	48,213,881.51
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,540,952.82	48,213,881.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	40,602,794.68
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,540,952.82	7,611,086.84
122	Тусламжийн орлого	-	139,625,842.76
122002	Хандив тусламж /гадаад/	-	139,625,842.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	446,907,489.60	332,529,576.17
2104	Хангамж, бараа материалын зардал	431,041,989.05	-
210410	Бараа материал худалдан авахад төлсөн	431,041,989.05	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,649,209.89	248,850,154.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,179,717.07	224,569,687.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	24,244,047.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	36,420.10
210813	Бусад зардал	2,469,492.82	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,216,290.66	10,046,640.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,216,290.66	9,046,640.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	40,602,794.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	40,602,794.68
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	40,602,794.68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	33,029,986.26
2200	Дотоод эх үүсвэрээр	-	33,029,986.26
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз /ТӨҮГ/	-	33,029,986.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(443,366,536.78)	(144,689,851.90)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	20,442,973.69	5,700,732.81
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	20,442,973.69	5,700,732.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,446,733.09
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	1,446,733.09
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	20,442,973.69	5,700,732.81
5	НИЙТ ҮР ДҮН	(422,923,563.09)	(140,435,852.18)

3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	179,228,637.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	179,228,637.44
120	Нийтлэг татварын бус орлого	-	39,602,794.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	39,602,794.68
122	Тусламжийн орлого	-	139,625,842.76
122002	Хандив тусламж /гадаад/	-	139,625,842.76
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,179,717.07	238,183,547.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,179,717.07	238,183,547.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,179,717.07	238,183,547.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,179,717.07	235,088,648.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,179,717.07	218,048,134.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	17,004,093.45
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	36,420.10
213	Урсгал шилжүүлэг	-	3,094,899.64
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,094,899.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(8,179,717.07)	(58,954,910.35)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	468,544,958.05	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	468,544,958.05	-
2200	Дотоод эх үүсвэрээр	468,544,958.05	-
220001	Барилга байгууламж	61,650,388.80	-
222001	Тоног төхөөрөмж	369,391,600.25	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,502,969.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(468,544,958.05)	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	(20,442,973.69)	(5,700,732.81)
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	20,442,973.69	5,700,732.81
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	20,442,973.69	5,700,732.81
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(456,281,701.43)	(53,254,177.54)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	600,622,915.79	144,341,214.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	144,341,214.36	91,087,036.82

3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,205,075.03	594,136,328.93	609,341,403.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,205,075.03	594,136,328.93	609,341,403.96
Тайлант үеийн үр дүн	-	(422,923,563.09)	(422,923,563.09)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,205,075.03	171,212,765.84	186,417,840.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,205,075.03	171,212,765.84	186,417,840.87
Тайлант үеийн үр дүн	-	(140,435,852.18)	(140,435,852.18)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,205,075.03	30,776,913.66	45,981,988.69

3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		144,341,214.36		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,200,000.00	235,088,648.15	111,351.85	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	235,200,000.00	235,088,648.15	111,351.85	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,200,000.00	235,088,648.15	111,351.85	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,200,000.00	235,088,648.15	111,351.85	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	235,200,000.00	235,088,648.15	111,351.85	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	235,200,000.00	139,625,842.76	95,574,157.24	59.3
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	235,200,000.00	139,625,842.76	95,574,157.24	59.3
Хандив тусламж /гадаад/	235,200,000.00	139,625,842.76	95,574,157.24	59.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		144,341,214.36		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,878,408.97		

3.6. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	ДАНСНЫ НЭР	Тайлант оны дүн
I	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	
II	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ОРЛОГО	
	Орлогын тохируулга:	
	Банкны хүүгийн орлого	40,602,794.68
	Тендерийн орлого	-
	Валютын ханшийн зөрүү	5,700,732.81
	Бусад авлага	-
III	ТОХИРУУЛСАН ОРЛОГЫН ДҮН	46,303,527.49
IV	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРЛАГА	
	Зарлагын тохируулга:	
	Бараа үйлчилгээний бусад зардал	3,094,899.64
	Банкны үйлчилгээний хураамж	-
	Тендерийн зардал	1,000,000.00
	Төвлөрүүлсэн зардал	-
V	ТОХИРУУЛСАН ЗАРЛАГЫН ДҮН	4,094,899.64
VI	Эхний үлдэгдлээс тохируулсан зардал	
VII	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (I+II-IV)	
	Эцсийн үлдэгдлээс тохируулсан орлого	
VIII	ТОХИРУУЛГЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ (III-V-VI)	42,208,627.85
IX	Тохируулсан орлого зарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (III-IV)	
X	Тохируулсны дараа нийт зарлагад тооцох дүн (IV-V-VI)	
XI	20... оны ..-р сарын .. хүртэлх хөрөнгө оруулалт	
XII	Хөрөнгө оруулалтын дараа нийт зарлагад тооцох дүн (X+XI)	
XIII	Төсвөөс санхүүжүүлэх цэвэр дүн	

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.